



МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 12 сарын 20 өдөр

Дугаар А/457

Мөрөн сум

Комисс томилох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 66 дугаар зүйлийн 66.1, Барилгын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.2, 35.1.6, 48 дугаар зүйлийн 48.1, 48.6, Засгийн газрын 2021 оны 212 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. “Оновчтой бодлого-Хариуцлагатай төсөв” дэд хөтөлбөрийн хүрээнд Мал аж ахуйн эрсдлийг бууруулж, малчдын амьжиргааг дэмжих өвсний саравч барих ажил хүлээж авах ашиглалтад оруулах чиг үүрэг бүхий комиссыг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Комиссын дарга: Б.Энхжаргал

(Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын Барилга хот байгуулалтын хэлтсийн дарга)

Гишүүд:

Д.Чинзориг

(Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлого төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн мэргэжилтэн)

Ж.Жавзанпагма

(Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн Архивын тасгийн дарга)

Э.Улам-Өсөх

(Хүнс, хөдөө аж ахуйн газрын Дотоод хяналт, шинжилгээ хариуцсан мэргэжилтэн)

Э.Сумъяасүрэн

(“Хөвсгөл барилга захилагчийн хяналтын төв” ОНӨААТҮГазрын хяналтын инженер)

Зураг төслийн байгууллагын төлөөлөл:

Д.Мөнх-Эрдэнэ

(“Адмо наяд” ХХК-ийн Захирал)

Гүйцэтгэгч байгууллагын төлөөлөл:

Д.Дарьбаатар

(“БУНБАХ” ХХК-ийн Захирал)

Ашиглагч байгууллагын төлөөлөл:

Б.Эрдэнэбилэг

(Мал хамгаалах сангийн менежер)

Комиссын нарийн бичгийн дарга:

Э.Аззаяа

(Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын Ахлах мэргэжилтэн)

2. Барилгын засварын өвсний саравчны ажлыг хүлээж авах үйл ажиллагааг холбогдох хууль, тогтоомжийн дагуу зохион байгуулж, комиссын ажлын тайлан, шийдвэрийг олон нийтэд мэдээллэх ажлыг зохион байгуулж ажиллахыг Комиссын дарга (Б.Энхжаргал)-д даалгасугай.

6711011742

3. Барилгын засварын өвсний саравчны ажлыг хүлээж авсантай холбоотой баримт бичгийг бүрдүүлэн аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн Архивын тасаг болон холбогдох байгууллагуудад хүлээлгэн өгөхийг Комиссын нарийн бичгийн дарга (Э.Аззаяа) -д үүрэг болгосугай.

4. Комиссын бүрэлдэхүүн чанаргүй барилга байгууламж хүлээн авсан тохиолдолд холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээлгүүлэхийг анхааруулсугай.

5.Захирамжийн биелэлтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газар (Б.Мөнгөн-Эрдэнэ)-т үүрэг болгосугай.

ДАРГА



Ш.ИДЭРБАЯСГАЛАН